



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 03

Цагаан-Овоо

Салбар чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3.4 тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас зээл олгох, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх салбар чиглэлийг хавсралтаар баталсугай.


2. Төслийг журмын дагуу сонгон шалгаруулж, иргэдийн оролцоог хангах, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг хорооны дарга (Б.Ганчимэг)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 сарын 28-ны өдрийн 40 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  ТАЛТАНГАДАС



Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны  
06 сарын 21-ний өдрийн 63 тоот  
тогтоолын хавсралт



Хоршоог хөгжүүлэх салбар чиглэл

№	Эдийн засгийн салбар	Чиглэл
1	Хүнсний үйлдвэр	-Сүү сүүн бүтээгдэхүүн -Талх нарийн боов, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл -Малын дайвар бүтээгдэхүүн, боловсруулах худалдаалах -Хоол үйлдвэрлэл
2	Хөнгөн үйлдвэр	-Төмөр эдлэл үйлдвэрлэл -Оёдол эсгүүр үйлдвэрлэл -Гутал үйлдвэрлэл -Модон эдлэл/ мужаан гэрийн тавилга/ -Сүлжмэл, нэхмэл, ноос ноолууран эдлэл -Хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах
3	Газар тариалан	-Төмс хүнсний ногоо -Мод, Жимс жимсгэнэ тариалах -Хүлэмжийн аж ахуй -Тэжээлийн ургамал тариалах
4	Мал аж ахуй	-Арьс шир боловсруулах -Эсгий эдлэл -Мал үржлийн ажил үйлчилгээ -Мал эмнэлэгийн ажил үйлчилгээ -Гахай шувууны туслах аж ахуй
5	Барилга	-Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл -Зөөврийн сууц, төмөр хашаа хийц
6	Үйлчилгээ	-Үсчин, гоо сайхан маникюр -Авто засвар, дугуй засвар -Гагнуур -Гутал засварын үйлчилгээ -Зочид буудал -Аялал жуулчлал -Алт мөнгөний дархан